



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА**

1100 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
13 дугаар хороо, 14 дугаар хороолол
Энэтхэгийн улсын чөлөөт
зона 25-21 кв. Факс: (976) 7714542/44
http://www.gov.mn

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ДЭРГЭДЭХ
ХЭЛТЭС, АЛБАДЫН ДАРГА НАРТ

2019 07 10 № 01/570
санал _____ тусгай _____

**Хуралдааны зөвлөмж хүргүүлэх
тухай**

Баянзүрх дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн хурлыг 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн анхдугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн дарга, гишүүдэд

1.1. Дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах;

1.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2019-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, үндсэн үйл ажиллагаатай уялдуулах;

1.3. Дүүргийн хэмжээнд онц чухал объектын жагсаалтыг шинэчлэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, гамшгаас хамгаалах албадын хэмжээнд гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, үнэлгээ хийх;

1.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ хөлбөгдөх санхүүжилтийг орон нутгийн төсөв, 2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлтөнд тусгаж хэрэгжүүлэх;

1.5. Ашиглалтын шаардлага хангахгүй сургууль, цацэрлэг, эмнэлэг, орон сууц, нийтийн үйлчилгээний барилгуудын судалгааг гаргаж газар хөдлөлт, тэсвэржилтийн үнэлгээг дүүргийн хэмжээнд зохион байгуулж их засвар, хүчитгэл, шинээр барихад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх, уламжлах;

1.6. Дүүрэгт гамшгийн аюулаас амжиж анхааруулах, эрт зарлан мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх;

1.7. Аюулт үзэгдэл, осол, гамшгийн цагийн байдлын талаарх мэдээ, мэдээллийн найдвартай, эх сурвалжийн нэгдмэл байдлыг хангаж, мэргэжлийн байгууллагууд хоорондын ажлын уялдааг хангах.

Хоёр. Хэвлэл мэдээллийн албанд

2.1. Дүүргийн иргэдэд гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг олгох, орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг оурталчлан таниулах, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах;

Гурав. Боловсролын хэлтэст

3.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг гамшгаас хамгаалах багаж хэрэгслээр хангах, аврах зам гарц, бүдүүвч зураг, тэмдэг тэмдэглэгээ байрлуулахад шаардагдах хөрөнгийн судалгааг гаргаж, үе шаттай шийдвэрлэх.

3.2. Сургууль, цэцэрлэгийн шатны хонгил, зам гарцын дагуу байрлуулсан шилэн хоргыг шилжүүлэн байршуулах ажлыг зохион байгуулах.

Дөрөв. Монголын Улаан загалмайн хороонд

4.1. Иргэд, олон нийтэд гамшгийн тухай ойлголт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, мэдлэг ойлголтыг олгоход чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Хавсралт 1 хуудастай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ

МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУД

2019 оны 07 дугаар сарын 09

Улаанбаатар хот

Д/д	Дүүргийн дэргэдэх хэлтэс, албад
1	Баянзүрх дүүргийн Татварын хэлтэс
2	Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс
3	Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
4	Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс
5	Баянзүрх дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс
6	Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтэс
7	Баянзүрх дүүргийн Статистикийн хэлтэс
8	Баянзүрх дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
9	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс
10	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс
11	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3 дугаар хэлтэс
12	Баянзүрх дүүрэг дэх замын цагдаагийн тасаг
13	Баянзүрх дүүргийн Улаан загалмайн хороо
14	Баянзүрх дүүргийн Газар зохион байгуулалтын алба
15	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв
16	Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс
17	Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар 1 ОНӨААТГ
18	Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар 2 ОНӨААТГ
19	Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар 3 ОНӨААТГ
20	Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар 4 ОНӨААТГ